

УС СУВГИЙН УДИРДАХ ГАЗАР
ЁС ЗҮЙН ДЭД ХОРОО

ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

2025 оны 07 дугаар сарын 04

Улаанбаатар хот

1. Ус сувгийн удирдах газрын дэргэдэх Ёс зүйн дэд хороо нь 2025 эхний хагас жилд цаасаар 1 өргөдөл, гомдол ирсэн, цахимаар өргөдөл, гомдол ирээгүй. Цаасаар ирсэн тус өргөдөл гомдлыг судлах явцад гомдол гаргасан болон гомдолд нэр дурдагдсан ажилтнууд уулзаж ойлголцсон тул гомдлоо буцааж авсан.
2. Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааны төлөвлөгөөнд нийт 15 ажил тусгагдсан бөгөөд дундаж биелэлт 73.3%-тай байна. Үүнд:
 - “Үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангах чиглэлээр 4 (32.5%)
 - Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр 5 (94%)
 - Төлөвлөх, үйл ажиллагааг хэрэгжүүлэх, тайлагнах чиглэлээр 6 (83.3%),
3. Ёс зүйн дэд хорооны хурлыг 3 удаа зохион байгуулж, дэд хорооны үйл ажиллагааны талаар хэлэлцсэн.
4. Байгууллагын Ёс зүйтэй ажилтнаар 2024 онд шалгарсан ажилтнуудтай цаашид хамтран ажиллах чиглэлээр санал солилцох уулзалтыг 2025 оны 03 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулсан.
5. Ёс зүйн дэд хорооноос ёс зүй, ажил хэргийн ёс зүйн зорилго, зарчмын талаар богино хэмжээний 4 төрлийн видео танилцуулга, мэдээллийн баннерыг бэлтгэн, ёс зүйн өдөрлөгийн үеэр ажилтнуудад үзүүлж, ёс зүйн талаар болон ажил хэргийн ёс зүйн талаарх ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэн ажиллаж байна.
6. Нөлөөллийн аяныг зохион байгуулах удирдамж, хуваарийг батлан гаргаж, хуваарийн дагуу Талархал, Уучлал, Ойлголцлын өдрийг байгууллагын нийт зохион байгуулалтын нэгж бүрд зохион байгуулж, тайлан, мэдээллийг байгууллагын дотоод фейсбүүкт байршуулан ажилласан.
7. Ёс зүйн өдөрлөгийг зохион байгуулах удирдамж, хуваарийг батлан гаргаж, хуваарийн дагуу 4 зохион байгуулалтын нэгжтэй хамтран өдөрлөгийг зохион байгуулж, тайлан, мэдээллийг байгууллагын дотоод фейсбүүкт байршуулан ажилласан.
8. Нийт ажилтнуудын ёс зүйн тухай ойлголт мэдлэгийг дээшлүүлэх сургалтыг Ёс зүйн академитай хамтран зохион байгуулсан бөгөөд нийт 1200 гаруй ажилтан цахимаар хамрагдсан.

УС СУВГИЙН УДИРДАХ ГАЗРЫН ЁС ЗҮЙН ДЭД ХОРОО